



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Г Г
Гүйцэтгэх захирлыг түр томилох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.9 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирлаар Эрдэнэбилэгийн Тамирыг 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн түр томилсугай.

2. Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн захирлын нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо /Д.Нямдэлгэр/-т үүрэг болгосугай.

3. Гүйцэтгэх захирал Э.Тамиртай “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г холбогдох журмын дагуу байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Уянга/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭХҮҮ